



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 130


Улаанбаатар хот

Олон улсын сувилагчдын
өдрийг тэмдэглэх тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, “Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийг хангах, **“Сувилагч шинэчлэгч хүч: үр дүнтэй, үр ашигтай тусламж”** сэдэв дор 2015 оны олон улсын сувилагчдын өдрийг дэлхий нийтээр тэмдэглэх болсон Олон улсын Сувилагчдын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2015 оны 05 дугаар сарын 12-ны өдөр тохиох олон улсын сувилагчдын өдрийг эрүүл мэндийн салбарт **“Сувилахуйн шинэчлэлийг удирдагчаас”** сэдвийн дор тэмдэглэсүгэй.
2. Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх нэгдсэн арга хэмжээнд оролцогчдын зардлыг тухайн байгууллагын томилолтын хүрээнд шийдвэрлэж, удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т үүрэг болгосугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080435

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 04 сарын 03 өдрийн
130 дугаар тушаалын хавсралт

ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧДЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго.

Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулахад үйл ажиллагааны үндсэн зорилго оршино.

Хоёр. Үйл ажиллагааны зорилт.

1. Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг дүгнэнэ.
2. “Сувилахуйн шинэчлэлийг удирдагчаас” сэдвийн дор 2015 оны олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна.
3. Сувилахуйн удирдлагын багийн нэгдмэл зорилгыг тодорхойлно.

Гурав. Үйл ажиллагаа.


3.1 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын нийтлэг хэрэгжүүлэх арга хэмжээ.

Хугацаа: 2015 оны тайлант хугацаанд

1. “Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн /цаашид Стратеги гэх/ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хамт олноор хэлэлцүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээг авч ажилласан байна.
2. Стратегийг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүнг тооцож, дүгнэлт гаргаж, үнэлгээ өгсөн байна.
3. Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Сувилагч мэргэжил миний бахархал” сэдвийн дор сувилагчийн нэг өдөр аяныг сувилахуйн тусламж, үйлчилгээний нээлттэй өдөрлөг хэлбэрээр зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.
4. Сувилагчдын эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг дэмжих, мэргэжил дээшлүүлэх, олгох сургалтад хамрагдсан, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлсэн байна.
5. Сувилагчдын гардан үйлдлийн ур чадварыг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулсан байна.
6. Үйл ажиллагааны тайланг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Эрүүл мэнд спортын яамны Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлсэн байна.

3.2 олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх нэгдсэн арга хэмжээ:

1. **Хугацаа:** 2015 оны 05 дугаар сарын 21-22 –ны хооронд.
2. **Зохион байгуулагдах газар:** Сэлэнгэ аймагт
3. **Гол зохион байгуулагч:** Эрүүл мэнд, спортын яам, Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар
4. **Оролцогчид:**
 - Аймгийн эрүүл мэндийн газрын дарга,
 - Аймгийн эрүүл мэндийн газрын сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн,
 - Аймгийн нэгдсэн эмнэлгийн сувилгааны албаны дарга,
 - НЭМГ-ын сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн,
 - Нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга, сувилгааны албаны дарга,
 - Нийслэлийн Баянзүрх, Сонгино хайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга, сувилгааны албаны дарга,
 - Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвийн дарга, захирал,
 - Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвийн сувилгааны албаны дарга.



5. **Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ерөнхий агуулга:**

1	СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ ХҮРЭЭНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГААС БЭЛТГЭЖ ИРЭХ ЗҮЙЛС:	
	Стратегийн шалгуур үзүүлэлтийн 2015 оны эхний хагас жилийн дүнг зөвхөн тоон үзүүлэлтээр А4-ийн хоёр нүүрэнд багтаасан нэгтгэл	
	Стратеги хэрэгжүүлж эхэлснээс /2012 оноос/ хойш шинээр хүрсэн, бодит, 3 сайн туршлагыг А4-ийн гурван нүүрэнд багтааж, зурагт үзүүлэн хэлбэрээр	
	Стратегийг бүрэн хэрэгжүүлж дуусгахад тухайн байгууллага, хамт олны хувьд хамгийн тулгамдаж буй 3 асуудал, шийдвэрлэх арга замын хамт А4-ийн гурван нүүрэнд багтаасан санал	
	“Сувилагчийн нэг өдөр” арга хэмжээг 2012-2015 оны хугацаанд зохион байгуулж, хүрсэн бодит нэг үр дүн, сайн туршлагыг баримтжуулж, А4-ийн нэг нүүрэнд багтаасан зурагт танилцуулга	
2015 онд зохион байгуулсан сувилагчдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн жагсаалт, Сувилагчдын төгсөлтийн дараах мэргэжил олгох сургалтад хамрагдсан 2015 оны эхний хагас жилийн дүнг 2014 оны байдалтай харьцуулсан дүн,		
2. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР САЙЖРУУЛАХ АСУУДЛААР:		
БАГААР АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ	ЧИГЛҮҮЛЭГЧ	ХҮРЭХ ҮР ДҮН
Бүлгийн ажил 1. Сувилагчийн хөтлөх бичиг баримтыг цөөрүүлэх зорилгоор компьютерийн програмд суулгах ажлын таблиц зохиох	О.Дагиймаа /Хөвсгөл аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн/	Ажлын ачаалал бууруулах бодлогын баримт бичиг гаргана

Бүлгийн ажил 2. Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар үнэлэх <u>шалгуур үзүүлэлт</u> боловсруулах	Г.Пүрэвдаваа /ЭХЭМҮТ-ийн САД/	Чанар үнэлэх аргачлал боловсруулна
Бүлгийн ажил 3. Сувилагчийн ажлын байрны тодорхойлолтын шинэчлэл	Д.Дүүмаам /Өмнөговь аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн/	Ажлын байрны тодорхойлолтыг шинэчилнэ
Бүлгийн ажил 4. Сувилагчийн ажлын ачаалал, норм, нормативыг судалж, үнэлгээ, дүгнэлт гаргах <u>аргачлал, асуумж</u> боловсруулж, хэлэлцүүлэх,	Д.Дуламсүрэн /ХСҮТ-ийн САД/	Бодлогын баримт бичигт тусгана
Бүлгийн ажил 5. Сувилахуйн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжид оруулах <u>шинэчлэлийн төсөл</u> боловсруулж, хэлэлцүүлэх,	Я.Энхжаргал /ЭМСЯ- Сувилахуйн мэргэжлийн зөвлөл/	Стандарт удирдамжийг шинэчилнэ
Бүлгийн ажил 6. Жишиг сувилгааны алба байгуулах <u>төсөл</u> боловсруулж, хэлэлцүүлэх	Д.Сонгиносүрэн /НЭМГын мэргэжилтэн/	Жишиг алба байгуулах төслийг ОУ-ын хандивлагч байгууллагаар шийдвэрлүүлнэ
Бүлгийн ажил 7. Сувилахуйн асуудлаар үндэсний хэмжээнд гаргаж байх <u>статистик мэдээллийн</u> төсөл хэлэлцүүлэх	Д.Нямсүрэн /УХТЭ-ийн САД/	Жил бүр статистик мэдээлэл гаргах сан бүрдүүлнэ
Бүлгийн ажил: 8 Сувилахуйн сургалтын агуулгын шинэчлэл, <u>сувилгааны түүх</u> , сувилгааны онош тавих арга барилыг сайжруулах асуудал	Ц.Басбиш Сувилахуйн сургуулийн суурь сувилахуйн тэнхимийн эрхлэгч	Сургалтын агуулгад шаардлагатай шинэчлэлийг хийх
3. ЭМНЭЛЭГ, ГАЗРЫН ДАРГА НАРЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭ:		
Бүлгийн ажил:1 Сувилагчийн пост, эмнэлгийн хүлээн авахын сувилагчийн постуудыг дотоод сүлжээ бүхий компютрээр хангах, холбох, шаардлагатай <u>төсөв, хөрөнгө, үр, ашгийн</u> тооцоо хийх <u>төсөл</u> боловсруулах	Ш.Энхтөр /ЭХЭМҮТ-ийн дарга/	Ажлын ачаалал бууруулах бодлогын баримт бичиг гаргана
Бүлгийн ажил:2 Сувилагчийн гүйцэтгэж буй тусламж, үйлчилгээний <u>чанар үнэлэх шалгуур</u> үзүүлэлт боловсруулах	Г.Баясгалан /УХТЭ-ийн дарга/	Чанар үнэлэх аргачлал боловсруулна
Бүлгийн ажил:3 Ээлжийн сувилагчийн <u>ажлын цагийг богиносгох</u> боломжит хувилбар боловсруулах	Л.Төмөрбаатар /ХСҮТ-ийн дарга/ /5 мин/	Эрх зүйн орчныг өөрчлөх баримт бичиг боловсруулна

<p>Бүлгийн ажил:4 Байгууллагын сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх боломж, гарцыг тодорхойлж, төсөл боловсруулах</p>	<p>Б.Бямбадорж /УНТЭ-ийн дарга/</p>	<p>Бодлогын баримт бичигт тусгах, холбогдох байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх</p>
<p>Бүлгийн ажил:5 Сувилагчийн ажлын ачаалал, норм нормативын дагуу цалин хөлсийг нэмэгдүүлж болох үр, ашгийн тооцоо /жишиг / боловсруулах</p>	<p>Чиглүүлэгч: Ц.Төмөр-Очир /УГТЭ-ийн дарга/</p>	<p>Хөгжлийн чиг баримжаа, дараачийн бодлого, стратегид тусгах зорилго, зорилтууд тодорхойлно</p>
<p>Бүлгийн ажил:6 <u>"Монголын сувилахуй - 2020 онд"</u> /Төсөөлөл/</p>	<p>Н.Одонгуа АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн Захирал, С.Алтанбагана /ЭТХ-ийн мэргэжилтэн/</p>	<p>Хөгжлийн чиг баримжаа, дараачийн бодлого, стратегид тусгах зорилго, зорилтууд тодорхойлно</p>
<p>Шаардлага: *Эдгээр баримт, бичгийг боловсруулахад тухайн байгууллагаас шаардлагатай, мэдээ, материалыг бэлтгэж авчирсан байна. *Чиглүүлэгчид тухайн асуудлаар одоогийн байдлыг танилцуулах, чиглүүлэх зорилго бүхий 5 минутад багтаасан илтгэлийг сонирхолтой хэлбэрээр бэлтгэн ирж, танилцуулна.</p>		

6. Хүрэх үр дүн:

1. Стратегийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, зөвлөмжид тусган хэрэгжүүлнэ.
2. Сувилахуйн тусламж, үйлчилгээний сайн туршлагаудыг бүртгэн авч, туршлага судлуулах, сурталчлах арга хэмжээг авна.
3. Сувилахуйн тусламж, үйлчилгээнд амжилт гаргасан тэргүүний хамт олныг шалгаруулж, урамшуулна.

7. Хяналт, үнэлгээ.

1. Эрүүл мэндийн байгууллагууд 2015 оны стратегийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн тоон дүн, бичмэл тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлэх,
2. Байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн үнэлгээнд энэхүү удирдамжийн хэрэгжилт, нэгдсэн арга хэмжээнд идэвхитэй оролцсон удирдлагын багийн амжилтыг оруулан тооцно.

8. Шагнал, урамшуулал.

1. Нэгдсэн арга хэмжээнд амжилттай оролцсон тэргүүн байрын -1, дэд байрын -2, гутгаар байрын-3 байгууллагыг багийн нэгдсэн дүнгээр тус, тус шалгаруулна.
2. Нэгдсэн арга хэмжээнд амжилттай оролцсон баг, хамт олны урамшуулал:
 - a. Тэргүүн байр эзэлсэн баг, хамт олонд өргөмжлөл, цом, 1 сарын үндсэн цалин,
 - b. Дэд байр эзэлсэн баг хамт олонд дэд байрын өргөмжлөл, 1 сарын үндсэн цалингийн 50 хувь,
 - c. Гутгаар байр эзэлсэн баг хамт олонд 1 сарын үндсэн цалингийн 30 хувийн урамшуулал олгож,

- d. Зохион байгуулсан үйл ажиллагаа, баг хамт олны амжилтыг Эрүүл мэнд, спортын яамны цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн мэдээлж, сурталчилна.
3. Тэргүүн байр эзэлсэн байгууллага, хамт олон 2016 оны олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулах эрхийг хүлээн авна.

